

ҮНЭТ ЦААС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ

Бонд эзэмшигч нь дараах эрхтэй байна. Үүнд:

- Бонд эзэмшигч нь дараах бичиг, баримтууд болон мэдээллийг шаардах эрхтэй. Үүнд:
 - Төслийн гүйцэтгэл, явцын талаар мэдээ тайлан, үйлдвэрлэл худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй холбогдсон баримт бичиг
 - Төслийн хөрөнгийн талаархи зарцуулалт, санхүүгийн бодит мэдээлэл
 - Бондын хоёрдогч зах зээлийн арилжааны үнэ, ханш болон арилжааны мэдээ
- Бонд эзэмшигч нь өөрийн эзэмшиж буй бондыг хоёрдогч зах зээл дээр чөлөөтэй арилжиж, захиран зарцуулах,
- Улирал бүрийн эцэст бондын хүүг тооцуулан авах, Үнэт цаас гаргагчаас Бондын хүүг хугацаандаа төлөхийг шаардах, хүү төлөх хугацаа хэтэрсэн тохиолдолд хүүгийн төлбөр дээр 0.02 хувийн алданги нэмж, тооцуулан авах,
- Хугацааны эцэст бондыг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хугацаа хэтэрсэн тохиолдолд баталгаа гаргасан хөрөнгөөр үүргийн гүйцэтгэл хангахыг шаардах, тооцуулан авах,
- Компанийн үйлдвэрлэл, борлуулалтын явц, гүйцэтгэлтэй холбоотой тодруулга, мэдээллийг Үнэт цаас гаргагч болон Андеррайтерын компаниас гаргуулан авах болон Монгол Улсын холбогдох хууль журамд заасан бусад эрхүүдийг эдэлнэ.

